ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. ***Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар*** нь ***Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах ахмадын төрийн бус байгууллага болон ахмадын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад төрийн бус байгууллага сонгон шалгаруулах*** зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь ***Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах ахмадын төрийн бус байгууллага болон ахмадын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад төрийн бус*** **байгууллагуудыг** сонгон шалгаруулах зорилготой болно.

3. Дэлгэрэнгүй жагсаалтад материал ирүүлэх байгууллагуудад тавигдах ерөнхий шаардлага:

- Улсын хэмжээнд ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг тухайн зөвлөх үйлчилгээний төслийг хэрэгжүүлэх мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж үзүүлэх мэргэжлийн өндөр ур чадвартай баг, бүрэлдэхүүнтэй байгууллага байна.
- Бүтээн байгуулалт, нийгэм, эдийн засгийн тодорхой салбар (боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, төрийн захиргаа), мэргэжлийн чиглэлээр ахмад настны эх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага байх бөгөөд тэтгэвэр авагч ахмад мэргэжилтэнтэй баг бүрэлдэхүүн байна.

Бүрдүүлэх материал:

1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын албан хүсэлт;
2. Байгууллагын танилцуулга, үйл ажиллагаа явуулдаг байр болон техник хэрэгсэлийн жагсаалт, зураг;
3. Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатоор баталгаажуулсан хуулбар; /Ахмад настны эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааны чиглэл нь 2021 оны 01.01-ээс өмнө байна./
4. Татвар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт;
5. Харилцагч банкны тодорхойлолт, хугацаа хэтэрсэн зээлийн төлбөргүй тухай тодорхойлолт
6. 2020 оны санхүүгийн тайлан;
7. Сүүлийн 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалт;
8. Сүүлийн 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлуудад ажилласан ахмад мэргэжилтний оролцоо, тоо;
9. Төслийн хүрээнд түр ажлын байртай болох ахмад мэргэжилтний тоо;
10. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх ахмад мэргэжилтний багийн гишүүдийн товч намтар, иргэний үнэмлэхийн хуулбар, мэргэжлийн дипломын хуулбар, тэтгэврийн дэвтрийн хуулбар;
11. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх ахмад мэргэжилтнүүдийн ажлын туршлагын дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх, утасны дугаар гэх мэт.

4. Дэлгэрэнгүй жагсаалтад ирүүлэх мэдүүлгийг 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн /Даваа гараг/ 11 .00 цагаас өмнө www.tender.gov.mn сайтаар цахим хэлбэрээр ирүүлнэ үү.
Дээрх материалуудыг бүрэн гүйцэд ирүүлэх бөгөөд зөвхөн шаардлага хангасан байгууллагуудыг хураангуй жагсаалтад оруулна.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо,
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар,
2 дугаар давхарт 204 тоот өрөө
Утас: 77771220
Цахим хаяг: www.hudulmur-halamj.gov.mn
Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем: www.tender.gov.mn